


# Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн сан” систем

# Сургалтад хамрагдах гарын авлага

Системд хандах линк:

http://hr.hdc.gov.mn/

**Бүртгэлтэй хэрэглэгч:**

Хэрэв өмнө нь бүртгүүлчихсэн бол
“Нэвтрэх нэр”- хэсэгт регистрийн дугаар

“Нууц үг” – Өөрийн бүртгүүлэхдээ үүсгэсэн нууц үгийг оруулах.

**Бүртгүүлэх** товч дарж бүртгүүлэх хуудас руу шилжинэ.

Шинэ хэрэглэгч та **Заавар харах** дарж зааварттай танилцана уу /Нэвтэрсний дараа “Тусламж” цэснээс бусад заавартай танилцаарай/

# БҮРТГЭЛ ҮҮСГЭХ ХУРААНГУЙ ЗААВАР

1. http://hr.hdc.gov.mn/ хаягаар нэвтэрч “Бүртгүүлэх” дарж бүртгүүлнэ /бүртгэлтэй бол дахин бүртгүүлэхгүй/
2. “Регистрийн дугаар”, “Эцэг эхийн нэр”, “Өөрийн нэр”, “Утасны дугаар”, “И-мэйл хаяг” /хувийн ашиглагддаг хаягаа оруулах-нууц үг сэргээх мэдэгдэл очиход ашиглагдах тул алдаагүй зөв бичсэн байх/, “нууц үг”, “нууц үг баталгаажуулах” /өөрийн мартахгүй байх нууц үг зохиож үүсгэнэ/ талбарыг Монгол хэлээр алдаагүй бөглөж, “үйлчилгээний нөхцөл” хэсгийг чагталсны дараа БҮРТГҮҮЛЭХ товчийг дарж бүртгүүлнэ.
3. НЭВТРЭХ товчлуур дарж Нэвтрэх нэр-Өөрийн регистер, Нууц үг- өөрийн зохиосон нууц үгийг бичиж програмд нэвтрэнэ.
4. Баруун дээд хэсэгт байх өөрийн нэр дээр дарж “Миний мэдээлэл” хэсгийг сонгож нээнэ.
5. “Ерөнхий мэдээлэл” хэсэгт байх “Мэдээлэл шинэчлэх” товчийг дарснаар таны мэдээлэл ХУР системээс баталгаажин ногоон өнгөтэй болно. /Жич: овог нэрийг алдаатай эсвэл латинаар бичсэн, бичиж дуусаад зай авсан тохиолдолд баталгаажихгүй/
6. Програмд дахин нэвтрэн орж бөглөгдөөгүй талбарын мэдээллийг бүрэн бөглөнө. /цээж зураг хэсэгт албан хувцастай эгц өөдөөс харсан зураг оруулна/
7. “Мэргэжил” гэсэн цонхыг дарж “Мэргэжил”, “Дипломын дугаар”, “Тушаалын огноо”/захирлын тушаал/, “Зардлын хэлбэр”, “Төгссөн сургууль” зэргийг сонгож хавсралт хэсэгт өөрийн дипломыг дүнгийн хавсралтын хамт **PDF** хэлбэрээр оруулж хадгална. /Монгол тал байхад болно/
8. Үндсэн болон төрөлжсөн, мэргэжил дээшлүүлэх сургалтаа мөн адил талбар бүрийн ард байх **+ товч** дарж бөглөнө.
9. Ажлын туршлагаа бөглөж, нотлох баримыг PDF-ээр хавсаргана /Өмнөх ажилласан туршлагаа бүрэн оруулна/
10. Таны ажлын туршлагыг танай ажил олгогч байгууллагын хүний нөөц баталгаажуулах үүрэгтэй.
11. Уг бүртгэл нь зөвхөн нэг удаа үүсгэх бөгөөд цаашид өөрчлөлтийн мэдээллээ оруулаад явна.
12. “Ерөнхий мэдээлэл”, “Мэргэжил”, “Ажлын туршлага”, “Боловсрол”, “Мэргэжлийн зэрэг”, “Сургалт”, “Дүйцүүлэх материал” хэсэгт өөрийн мэдээллээ бүрэн бөглөөрэй.

**Бүртгэл үүсгэх дэлгэрэнгүй заавартай танилцаарай**

# СУРГАЛТАД БҮРТГҮҮЛЭХ ХУРААНГУЙ ЗААВАР

- СУРГАЛТАД БҮРТГҮҮЛЭХИЙН ӨМНӨ БҮРТГЭЛ ҮҮСГЭХ ЗААВРЫН ДАГУУ МЭДЭЭЛЛЭЭ БҮРЭН БӨГЛӨӨГҮЙ ТОХИОЛДОЛД ЗАР ХАРАГДАХГҮЙ БОЛНО.
- Зарлал – Сургалтын зар дээр даран сургалтын зараа харна.
- Элсэх сургалтаа сонгон **Бүртгүүлэх** товч дарж сургалтын мэдээлэлтэй танилцан бүртгүүлэх хүсэлтээ илгээнэ.
- Миний мэдээлэл – Сургалт цэсэнд **Хүлээн аваагүй** тэмдэглэгээ үүссэн бол сургалтад бүртгэгдсэн гэж ойлгоно.
- Сургалт эрхлэгч байгууллага таны хүсэлттэй танилцан шаардлага хангасан тохиолдолд хүсэлтийг зөвшөөрч, тэмдэглэгээ **Хүлээн авсан** болж өөрчлөгдсөнөөр та сургалтад элсэнэ. Мөн програмд илгээмж очих болно.
- Сургалт эрхлэгч байгууллага таны хувийн мэдээлэлтэй танилцаад сургалтад суулгахаас **Татгалзах** эрхтэй. Татгалзсан шалтгаантай илгээмж хэсгээс танилцаарай.
- Сургалтаа амжилттай дүүргэсэн тохиодолд **Амжилттай** төлөвт шилжин танд багц цаг тооцогдож мэдээллээ зөвшөөрөл сунгахад ашиглах боломжтой болно.
- Сургалт дууссан байхад хүсэлтийг **Хүлээн аваагүй** байвал Сургалт зохион байгуулсан байгууллагатай холбогдоно уу. Таны сургалтад суух хүсэлтийг хүлээн авалгүй, ирц хангалтгүй гэж үзэн сургалтыг дуусгасан бол багц цаг нөхөж авах боломжгүй.

# 1. Зарлал > Сургалтын зар – Зар харах




**Алхам: 1**

<u>Зарлал -> Сургалтын зар</u> цэсэд таны мэргэжлийн чиглэлд хамаарал бүхий сургалтын жагсаалт харагдана.

**Алхам: 2**

**БҮРТГҮҮЛЭХ** дээр дарж сургалтын дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжтой.




**<u>Хувийн мэдээлэл - Мэргэжил</u>** хэсэгт таны бөглөсөн чиглэлийн дагуу сургалт л танд харагдах тул, Мэргэжил, Үндсэн, Төрөлжсөн мэргэшлээ **Бүртгэл үүсгэх заавраас** харж бүрэн бөглөнө үү.

*Эзэмшээгүй буюу системд бүртгээгүй мэргэжлийн сургалтууд нь харагдахгүй болно.*

# Сургалт| Сургалтанд бүртгүүлэх




Байгууллага хариуцсан админд бүх сургалт харагдах боловч зөвхөн таны мэргэжилд тохирох сургалтад бүртгүүлэх боломжтой тул орох боломжгүй сургалтад таны нэр гарч ирэхгүй болохыг анхаарна уу.

**Алхам: 3**

**Сургалтад бүртгүүлэх хүсэлт илгээх** товч дарна. Сургалтад бүртгүүлэх хүсэлт илгээх цонх нээгдэнэ./зураг2/




**Алхам 4**

Төлбөрийн хэлбэр: Хувийн | Улсын | Төсөл, хөтөлбөрийн гэсэн гурван төрлөөс сонгоод **Хүсэлт илгээх** товч дараад ок дарснаар таны хүсэлт илгээгдэнэ.
Улсын төсвөөр сурах бол байгууллагаа сонгоно. Улсын гэсэн сонголтод НЭМГ, АЭМГ-ын захиалгыг ойлгоно.

# Зарлал -> Сургалтын зар – Сургалтын хүсэлт шийдвэрлэлт




**Сургалтанд бүртгүүлэх хүсэлт илгээгдсэн**

Хүсэлт амжилттай илгээгдсэн бол таны бүртгүүлэх хүсэлт илгээсэн сургалтын дэлгэрэнгүй мэдээлэл дотор дараах мэдээлэл харагдаж байх болно.







**Сургалтын хүсэлтийг хүлээн авсан** бол баталгаажуулалтын түүх дарж хүсэлт баталсан огноо, ажилтны нэртэй танилцана.

**Сургалтын хүсэлтийг татгалзсан** бол Баталгаажуулалтын түүх дарж буцаасан огноо, ажилтны нэр, тайлбартай танилцана.




Анги дүүргэлт, ажилтны эзэмшсэн мэргэшил, ажлын туршлагаас шалтгаалан татгалзах асуудлыг сургалт зохион байгуулагч шийдвэрлэнэ.



# **Сургалт|** Сургалтад амжилттай бүртгүүлсэн.

Таны хүсэлтийг Сургалт эрхлэгч байгууллагаас баталсан бол таньд илгээмж ирэх ба тухайн илгээмж дээр дарвал “Сургалтын нэр – сургалтанд бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авлаа” гэсэн илгээмж ирсэн байна.




Танхимаар болон онлайнаар тухайн сургалтад хамрагдаад амжилттай дүүргэвэл админаас бүртгэлийг баталгаажуулж та сургалтанд хамрагдсан түүхтэй болно.



# Сургалт| Сургалтын амжилт







**Сургалт дууссан.**

Сургалт явагдаж дуусах үед админаас сургалтыг дуусгах ба дуусгасан тухай илгээмж ирнэ. Дарж орвол сургалтын төлөв **ДУУССАН** болсон байна. /Зураг 1/

**Миний мэдээлэл – Сургалт - Системийн сургалт**

Таны хамрагдсан сургалтын мэдээлэл бөглөгдөж багц цагтай болсон байна. /Зураг 2/ Ингэснээр багц цагийн гэрчилгээ шаардлагагүй бөгөөд энэхүү мэдээллээ ашиглан багц цагаар зөвшөөрлөө сунгуулж болно.

# Миний мэдээлэл – Сургалт

Ерөнхий мэдээлэл | Мэргэжил | Ажлын туршлага | Боловсрол | Лиценз | Зэрэг | Сургалт | Гишүүнчлэл | Шалгалт | Дүйцүүлэх материал | НД лавлагаа

Сургалтын мэдээлэл татах

**surgalt.hdc.gov.mn програмаар багц цаг бүрдүүлсэн тохиолдолд таны мэргэжлийн чиглэлд тохирсон сургалт бол мэдээлэл татах дээр дарахад багц цаг тань нэмэгдэж орно**

Системийн бус сургалт

| Улс | Байгууллага | Сургалтын нэр | Сургалтын төрөл | Эхэлсэн хугацаа | Дууссан хугацаа | Кредит | Хавсралт | + |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Монгол | Оточ манрамба их сургууль | Ханиур засал, түүний онол арга зүй | Багц цагийн сургалт | 2017-10-14 | 2017-10-14 | 1 | | |
| Монгол | Этүгэн их сургууль | Зүрх судасны зонхилон тохиолдох өвчний орчин үеийн оношилгоо эмчилгээний чиг хандлага | Багц цагийн сургалт | 2017-10-21 | 2017-10-21 | 2 | | |
| Бүгд Найрамдах Хятад Ард Улс | Шинжлэх ухаан технологийн яам, Олон улсын харилцааны газар | Mongolian medicine professional Training course | Багц цагийн сургалт | 2023-01-03 | 2023-01-16 | 4 | | |

2020 оноос өмнөх багц цагийн мэдээлэл орно. Зөвшөөрөл сунгахад ашиглагдсан сургалтын мэдээлэл дахин ашиглагдах боломжгүйгээр ингэж түгжигдэнэ

Гадаад сургалтын мэдээллээ оруулж, засварлаж болно. Цэнхэр үзэг нь ашиглагдаагүй багц болохыг илтгэнэ.

Системийн сургалт

| Байгууллага | Сургалтын нэр | Сургалтын төрөл | Сургалтын дэд төрөл | Сургалтын хэлбэр/цахим, танхим/ | Эхэлсэн хугацаа | Дууссан хугацаа | Кредит | Төлөв |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ТЭЖЭЭХҮЙ УХААН | Уламжлалт анагаах ухааны хүүхдийн өвчин судлал | Багц цагийн сургалт | Эмнэлзүйн сургалт | | 2022/08/27 10:00 | 2022/08/27 18:00 | 2 | АМЖИЛТТАЙ |
| Улсын нэгдүгээр төв эмнэлэг | Яаралтай тусламж /бага эмч/ - 2023 намар | Дээшлүүлэх сургалт | Эмнэлзүйн сургалт | Танхимын сургалт | 2023/10/09 00:00 | 2023/12/15 00:00 | 8 | ТАТГАЛЗСАН |
| Эм зүйн шинжлэх ухааны их сургууль | Эмэгтэйчүүдийн хий бүрэлдсэн өвчний оношилгоо, эмчилгээ | Багц цагийн сургалт | Эмнэлзүйн бус сургалт | Танхимын сургалт | 2023/10/28 08:00 | 2023/10/28 17:59 | 1.0 | ХҮЛЭЭН АВСАН |
| Улсын нэгдүгээр төв эмнэлэг | Дотрын өвчний зонхилон тохиолдох эмгэгүүд | Багц цагийн сургалт | Эмнэлзүйн бус сургалт | Танхимын сургалт | 2023/12/01 09:00 | 2023/12/01 17:00 | 1 | ХҮЛЭЭН АВААГҮЙ |

Амжилттай суралцсан сургалтын мэдээллийг зөвшөөрлөө сунгуулахад ашиглах боломжтой болно

Сургалт эрхлэгч байгууллага таны хувийн мэдээлэлтэй танилцаад сургалтад суулгахаас татгалзах эрхтэй

Таны хүсэлтийг хүлээн авсан тул товлосон хугацаандаа сургалтдаа сууж ирцээ бүртгүүлээрэй

Таны сургалтад суух хүсэлтийг хүлээн аваагүй байгаа тул Сургалт явуулсан байгууллагатай холбогдоно уу
Таны сургалтад суух хүсэлтийг хүлээн авалгүй, ирц хангалтгүй гэж үзэн сургалтыг дуусгасан бол багц цаг нөхөж авах боломжгүй



Заавартай бүрэн танилцсан танд баярлалаа

ТАНЫ БОЛОВСРОЛЫН ТҮҮХИЙГ БИД ХӨТЛӨЕ

www.hr.hdc.gov.mn